



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянговь сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/20/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2020 он</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: bunkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Б.Цэрэнчимэд Утас: 88117644 Цахим хаяг: tserenchimedb@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Аудитын гэрчилгээ	3
Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг, төлөвлөлтийн шатанд тооцсон 7529,9 мянган төгрөгөөр тооцож баталгаажуулав.....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.13. Шилэн дансны мэдээлэл	8
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	10
1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	10
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	11
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	13
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	15
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	15



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

「 БАЯНГОВЬ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА М.ӨЛЗИЙЖАРГАЛ
ТАНАА

᠑᠐᠒᠐.᠐᠒.᠒᠐ № 1/14᠐

танай _____ -ны № _____ -т

「 Аудитын гэрчилгээ 7

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны Баянговь сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянговь сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянговь сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

005020082

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

2.1. Оршил

Баянговь сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Баянговь сумын Эрүүл мэндийн төвийн дарга М.Өлзийжаргал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянговь сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянговь сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 14-нөөс 2020 оны 01 дүгээр сарын 18-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Төрийн аудитын газрын аудитор Б.Цэрэнчимэд хариуцаж хэрэгжүүлэв.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Баянговь сумын Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Эрүүл мэндийн анхан шатны болон эмнэлгийн тусламж үйлчилгээг чанартай, шуурхай хүргэж үйлчлүүлэгчдэд ээлтэй орчин бүрдүүлэн, хувь хүн хамт олны идэвхтэй оролцоонд

тулгуурлан эрсдэлтэй зан үйлийг өөрчлөх, эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх замаар хүн амын эрүүл мэндийг сайжруулахад оршино” гэжээ.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Баянговь сумын Эрүүл мэндийн төв нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг батлуулаагүй, ашиглаагүй байна.

Баянговь сумын Эрүүл мэндийн төв нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд Санхүүгийн тооцоолох групп ХХК-ийн “Acolous” программ хангамж ашигладаг байна.

Баянговь сумын Эрүүл мэндийн төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд 31 гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Баянговь сумын Эрүүл мэндийн төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 31 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд/” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2,0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 376497,3 мянган төгрөгөөс тооцон 7529,9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг, төлөвлөлтийн шатанд тооцсон 7529,9 мянган төгрөгөөр тооцож баталгаажуулав.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянговь сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 88834,2 мянган төгрөгөөр буюу 22,6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-		-

Авлага		2,144.10	2,144.10
Урьдчилгаа	-		-
Бараа материал	12,331.70	9,241.20	(3,090.50)
Үндсэн хөрөнгө	461,253.30	377,078.60	(84,174.70)
Хуримтлагдсан элэгдэл	(87,679.70)	(91,392.90)	(3,713.20)
Биет бус хөрөнгө	7,656.00	7,456.00	(200.00)
Хуримтлагдсан элэгдэл	(650.00)	(450.00)	200.00
Нийт хөрөнгө	392,911.30	304,077.10	(88,834.20)
Өр төлбөр			-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	296,933.60	296.933.6	
Тайлант үеийн үр дүн		(88,834.20)	(88,834.20)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	392,911.30	304,077.00	(88,834.30)

Авлага дансны үлдэгдэл 2144,1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд НДШ илүү төлсөнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 3090,5 мянган төгрөгөөр буурсан нь тусгай зориулалтын материалаас 1006,4 мянган төгрөг, аж ахуйн материалаас 5422,8 мянган төгрөгийн хөрөнгө актлагдсан болон бусад бараа материалын орлого, зарлагын өөрчлөлт нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 84174,7 мянган төгрөгөөр буурсан нь аймгийн ИТХТ-ийн болон сумын ИТХ-ын шийдвэрээр 101078.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталж, шинээр 16903.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө орлого авч, нийт дүнгээрээ 84174.7 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгийн үлдэгдэл буурахад нөлөөлжээ

Биет бус хөрөнгө 200,0 мянган төгрөгөөр буурсан нь 200,0 мянган төгрөгийн үнэ бүхий программ актлагдсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 88834,0 мянган төгрөгөөр буурсан нь үр дүнгийн өөрчлөлт нөлөөлсөн байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын төсвийн тухай хуульд зааснаар Баянговь сумын Эрүүл мэндийн төв тайлант онд орлого төвлөрүүлэх төлөвлөгөө батлагдаагүй, үндсэн болон нэмэлт дансаар орлого бүртгэгдээгүй байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 4 /80101, 80109, 80302, 81603/ хөтөлбөрт зориулан 370897,3 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 358743,7 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 318383,8 мянган төгрөгийг улсын, 23583,9 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 28929,6 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Улсын болон орон нутгийн төсвөөс авах санхүүжилтийг бүрэн, Эрүүл мэндийн даатгалын сангаас гүйцэтгэлээр санхүүжүүлснээс шалтгаалан санхүүжилтийг 7195,8 мянган төгрөгөөр дутуу авсан байна.

Тайлант онд батлагдсан төсвийг хэтрүүлэн зарцуулаагүй бөгөөд байр ашиглалтай холбоотой зардлыг 4639,7 мянган төгрөгөөр хэмнэж буцаан төвлөрүүлсэн, ЭМДСангаас авах санхүүжилт дутуугаас шалтгаалж хангамжийн зардлыг 3040,9 мянга, нормативт зардлыг 2930,2 мянга, эд хогшил, урсгал засварын зардлыг 1273,3 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

Нэмэлт төсөв: Тайлант онд орлого төвлөрүүлэх төлөвлөгөө батлагдаагүй, үндсэн болон нэмэлт дансаар орлого бүртгэгдээгүй байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 33 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 34 эрсдэл тодорхойлж нийт 28 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 2537,3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 1115,0 мянган төгрөгийн алдааг залруулж, 132,0 мянган төгрөгийн зөрчилд акт тогтоож, 1290,3 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 132,0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс төлбөрийн акт тогтоов. Үүнд:

Бараа материалын тайланд 2019 онд шинээр худалдан авсан 22,0 мянган төгрөгийн үнэтэй 6 ширхэг уртасгагчийг зарлага гаргаж зардалд бичсэн байна.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 5-р зүйлийн 5.1 Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална, 5.1.4 "үнэн зөв байх", 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно, 13-р зүйлийн 13.7.Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно. гэсэн хуулийн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: 132,0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоов.

Аудитаар илэрсэн 1290,3 мянган төгрөгийн алдаа, зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татсан асуудал илрээгүй болно.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Баянговь сумын Эрүүл мэндийн төвийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 133 мэдээллийг хугацаанд нь, 16 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, хугацаа болоогүй 2 мэдээллийг байршуулаагүй байна.

д/д	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	3	6	2
2	Хагас жил	4	4	4	0	0
3	Улирал бүр	1	4	2	2	0
4	Сар бүр	3	36	32	4	0
5	Тухай бүр	8	96	92	4	0
	Нийт	27	151	133	16	2

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг “Глобаль капитал аудит” ХХК гүйцэтгэсэн, аудитаар акт, албан шаардлага, зөвлөмж өгөөгүй байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянговь сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Баянхонгор аймгийн Баянговь сумын ЭМТөвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Цалингийн зардлаас ажлаас чөлөөлөгдсөн иргэн Цэрэнтогтох, тэтгэвэрт гарсан Оюунгэрэл нарт 1 сарын тэтгэмж 1290,3 мянган төгрөг олгосон нь ажлаас чөлөөлөгдөж ажилгүй байх хугацаанд даатгалаас ажилгүйдлийн тэтгэмж, тэтгэвэрт гарсан ажилтанд төрөөс олгож байгаа тэтгэмжтэй давхардаж төсвийн хөрөнгийн зарцуулалт үр ашиггүй байгааг илэрхийлж байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1"Ажил олгогч нь энэ хуулийн 37.1.6, 40.1.1, 40.1.2, 40.1.3-т заасан үндэслэлээр ажлаас халагдсан ажилтанд нэг сар, түүнээс дээш хугацааны дундаж цалин хөлстэй тэнцэх тэтгэмж олгоно", Засгийн газрын 2014 оны 405 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам"-ын 3-т "Төрийн албаны тухай хуулийн 24.1.1, 24.1.2-т заасан үндэслэлээр төрийн албанаас чөлөөлөгдөж, тэтгэвэр тогтоолгосон төрийн жинхэнэ албан хаагчид хамгийн сүүлд хашиж байсан албан тушаалын нэг сарын үндсэн цалинг нь төрийн албанд ажилласан нийт жилийн тоогоор үржүүлсэнтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тусламж олгоно" гэсэн хуулийн заалттай нийцэхгүй байна.

1.2. Эрсдэл: Хөрөнгө мөнгө завшигдах

1.3. Өгсөн зөвлөмж:

Засгийн газрын 2014 оны 405 тогтоолоор батлагдсан журам болон нийгмийн даатгалын ажилгүйдлийн сангаас олгож буй тусламж, тэтгэмжтэй давхардуулж байгууллагаас олгож байгаа тэтгэмж, тусламжийг цаашид зогсоох

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөрчлийг давтан гаргахгүй, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

1.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: Баянговь сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	12,331,720.76	11,385,358.42
33	АВЛАГА	00.00	2,144,178.42
335	Бусад авлага	00.00	2,144,178.42
3351	Байгууллагаас авах авлага	00.00	2,144,178.42
35	БАРАА МАТЕРИАЛ	12,331,720.76	9,241,180.00
351	Түүхий эд материал	1,006,404.00	00.00
35110	Тусгай зориулалттай материал	1,006,404.00	00.00
354	Хангамжийн материал	11,325,316.76	9,241,180.00
35410	Бичиг хэргийн материал	1,357,140.00	720,080.00
35420	Аж ахуйн материал	8,752,110.76	5,536,250.00
35450	Барилгын засварын материал	400,000.00	00.00
35460	Хүнсний материал	273,066.00	1,208,950.00
35470	Бусад хангамжийн материал	543,000.00	1,775,900.00

2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	380,579,607.24	292,691,730.33
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	380,579,607.24	292,691,730.33
392	Биет хөрөнгө	373,573,607.24	285,685,730.33
39201	Барилга, байгууламж, орон сууц	309,562,401.95	226,072,142.88
39202	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-5,875,494.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	37,531,568.00	33,610,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-6,564,484.62	-7,017,916.58
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	100,321,477.87	102,675,925.87
39206	Хуримтлагдсан элэгдэл	-71,157,706.34	-70,372,389.08
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,848,850.00	12,731,550.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-8,554,204.84	-6,558,043.98
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,989,000.00	1,989,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-1,403,294.78	-1,569,044.78
393	Биет бус хөрөнгө	7,006,000.00	7,006,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	7,656,000.00	7,456,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-650,000.00	-450,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	392,911,328.00	304,077,088.75
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	392,911,328.00	304,077,088.75
51	Засгийн газрын хувь оролцоо	392,911,328.00	304,077,088.75
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	296,933,621.64	296,933,621.64
51101	Өмч: - төрийн	296,933,621.64	296,933,621.64
512	Хуримтлагдсан үр дүн	-111,634,275.24	-51,506,485.92
51210	Өмнөх үеийн үр дүн	-111,634,275.24	37,327,753.33
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-88,834,239.25
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	207,611,981.60	58,649,953.03
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	392,911,328.00	304,077,088.75

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: Баянговь сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	353,253,858.00	369,301,480.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	317,520.00	5,600,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	317,520.00	5,600,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	317,520.00	5,600,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	317,520.00	5,600,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	65,015,238.00	45,317,680.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	26,850,000.00	00.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	26,850,000.00	00.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	287,921,100.00	318,383,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	30,482,898.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,482,898.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	23,583,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	23,583,900.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	7,682,340.00	21,733,780.00

134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	7,682,340.00	00.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	00.00	21,733,780.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	341,557,183.47	376,497,315.61
21	УРСГАЛ ЗАРДАЛ	341,557,183.47	376,497,315.61
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	303,020,541.91	371,539,522.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	180,738,422.00	232,490,275.00
210101	Үндсэн цалин	180,338,722.00	220,821,800.00
210102	Нэмэгдэл	00.00	5,661,592.00
210104	Урамшуулал	399,700.00	6,006,883.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,785,123.21	25,000,013.58
210201	Тэтгэврийн даатгал	21,785,123.21	19,629,614.93
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	1,287,761.65
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	938,353.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	215,602.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	2,928,682.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,385,781.00	16,086,122.00
210301	Гэрэл, цахилгаан	1,494,316.00	6,893,578.00
210302	Түлш, халаалт	11,091,465.00	8,792,544.00
210303	Цэвэр, бохир ус	1,800,000.00	400,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	31,746,821.00	42,570,020.76
210401	Бичиг хэрэг	3,868,210.00	1,667,760.00
210402	Тээвэр, шатахуун	17,217,000.00	21,840,790.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	712,800.00	2,016,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	205,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,948,811.00	16,840,470.76
2105	Нормативт зардал	25,593,086.00	26,490,857.80
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	18,963,400.00	19,893,791.80
210502	Хоол, хүнс	6,629,686.00	6,597,066.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,056,350.00	850,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	800,000.00	00.00
210604	Урсгал засвар	8,256,350.00	850,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,430,000.00	2,378,000.00
210702	Дотоод албан томилолт	1,430,000.00	2,378,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	69,855.00	00.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	36,855.00	00.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,215,103.70	25,674,233.27
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,505,100.00	2,520,860.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	15,710,003.70	23,153,373.27
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,536,641.56	4,957,793.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,165,238.00	00.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	7,682,340.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	30,482,898.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	371,403.56	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	371,403.56	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	4,639,727.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	4,639,727.00

2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	318,066.20
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	318,066.20
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	11,696,674.53	-7,195,835.61
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	915,950.74	81,638,403.64
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	81,638,403.64
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	915,950.74	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-915,950.74	-81,638,403.64
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	10,780,723.79	-88,834,239.25

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: Баянговь сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	326,086,338.00	363,801,480.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	100,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	100,000.00
120009	Бусад орлого	00.00	100,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	326,086,338.00	363,701,480.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	287,921,100.00	318,383,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	30,482,898.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	30,482,898.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	23,583,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	23,583,900.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	7,682,340.00	21,733,780.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	7,682,340.00	00.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	00.00	21,733,780.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	326,086,338.00	352,497,580.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	326,086,338.00	352,497,580.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	287,549,696.44	347,539,786.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	180,664,977.24	229,995,300.00
210101	Үндсэн цалин	136,231,941.24	169,316,200.00
210102	Нэмэгдэл	30,572,100.00	47,808,700.00
210104	Урамшуулал	13,860,936.00	12,870,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,864,588.20	28,624,167.00
210201	Тэтгэврийн даатгал	21,864,588.20	19,290,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	2,364,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	1,814,786.00
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	424,681.00
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	4,729,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,365,781.00	15,944,173.00
210301	Гэрэл, цахилгаан	1,474,316.00	1,552,113.00

210302	Түлш, халаалт	11,091,465.00	13,992,060.00
210303	Цэвэр, бохир ус	1,800,000.00	400,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	20,149,500.00	26,314,039.00
210401	Бичиг хэрэг	820,300.00	1,200,000.00
210402	Тээвэр, шатахуун	17,217,000.00	20,690,090.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	712,800.00	2,016,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,399,400.00	2,407,949.00
2105	Нормативт зардал	27,757,500.00	30,868,741.80
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	18,963,400.00	21,458,791.80
210502	Хоол, хүнс	6,288,600.00	6,899,950.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,505,500.00	2,510,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,665,000.00	2,711,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,100,000.00	701,700.00
210604	Урсгал засвар	2,565,000.00	2,010,000.00
2107	Томилолт, зочны зардал	902,000.00	1,818,000.00
210702	Дотоод албан томилолт	902,000.00	1,818,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	62,000.00	400,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	400,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	62,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,118,350.00	10,863,666.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,118,350.00	10,863,666.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	38,536,641.56	4,957,793.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	38,165,238.00	00.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	7,682,340.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	30,482,898.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	371,403.56	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	371,403.56	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	4,639,727.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	4,639,727.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	318,066.20
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	318,066.20
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	11,303,900.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	11,303,900.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	11,303,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	11,303,900.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	11,303,900.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-11,303,900.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: Баянговь сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөг/
				Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	296,933,621.64	207,611,981.60	-111,634,275.24	392,911,328.00
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	296,933,621.64	207,611,981.60	-111,634,275.24	392,911,328.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	148,962,028.57	148,962,028.57
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	296,933,621.64	207,611,981.60	37,327,753.33	541,873,356.57
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-148,962,028.57	00.00	-148,962,028.57
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-88,834,239.25	-88,834,239.25
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	296,933,621.64	58,649,953.03	-51,506,485.92	304,077,088.75

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: Баянговь сумын Эрүүл мэндийн төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	370,897,400.00	358,743,686.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	370,897,400.00	358,743,686.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	370,897,400.00	358,743,686.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	229,995,300.00	229,895,300.00
210101	Үндсэн цалин	169,316,200.00	169,216,200.00
210102	Нэмэгдэл	47,808,700.00	47,808,700.00
210104	Урамшуулал	12,870,400.00	12,870,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,749,500.00	28,624,167.00
210201	Тэтгэврийн даатгал	19,290,300.00	19,290,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,364,800.00	2,364,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,891,800.00	1,814,786.00
210204	Ажилгүйдлийн даатгал	473,000.00	424,681.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,729,600.00	4,729,600.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,583,900.00	15,944,173.00
210301	Гэрэл, цахилгаан	1,473,200.00	1,552,113.00
210302	Түлш, халаалт	18,710,700.00	13,992,060.00
210303	Цэвэр, бохир ус	400,000.00	400,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	29,355,000.00	26,314,039.00
210401	Бичиг хэрэг	1,200,000.00	1,200,000.00

210402	Тээвэр, шатахуун	24,139,000.00	20,690,090.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,016,000.00	2,016,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.00	2,407,949.00
2105	Нормативт зардал	33,799,000.00	30,868,741.80
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	24,389,000.00	21,458,791.80
210502	Хоол, хүнс	6,900,000.00	6,899,950.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,510,000.00	2,510,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,905,000.00	11,631,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,505,000.00	8,631,700.00
210602	Тавилга	1,400,000.00	00.00
210604	Урсгал засвар	3,000,000.00	3,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,820,000.00	1,818,000.00
210702	Дотоод албан томилолт	1,820,000.00	1,818,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	400,000.00	400,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	400,000.00	400,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	00.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13289700.00	13247566.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,289,700.00	13,247,566.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	370,897,300.00	358,743,686.80
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	318,383,800.00	318,065,733.80
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	318,383,800.00	318,065,733.80
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	23,583,900.00	18,944,173.00
132001	Орон нутгийн төсвөөс	23,583,900.00	18,944,173.00
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	28,929,600.00	21,733,780.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	28,929,600.00	21,733,780.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	22	20
620001	Удирдах ажилтан	01	01
620002	Гүйцэтгэх ажилтан	16	15
620003	Үйлчлэх ажилтан	05	04
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	23	19
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	18	14
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	05	05

АУДИТЫН ТАЙЛАНГ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР:



Б.ЦЭРЭНЧИМЭД 2020.02.20

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР:



А.ЦЭЭНЯМ 2020.02.20

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ 2020.02.20